

Сэдэв 1.

Тогтвортой бичил санхүү

З.Оюунцацрал (PhD), СЭЗИС

2021.03.31

Агуулга

- ▶ Тогтвортой хөгжил
 - ▶ Зорилтууд
 - ▶ Тогтвортой хөгжил ба тогтвортой санхүү
- ▶ Тогтвортой санхүү
 - ▶ Тогтвортой бичил санхүүгийн 3 тулгуурт зорилт
 - ▶ Тогтвортой хөгжлийг дэмжихэд санхүүгийн байгууллагын үүрэг
- ▶ Бичил санхүү
- ▶ Тогтвортой бичил санхүү
 - ▶ Ногоон бичил санхүүжилт гэж юу вэ?
 - ▶ Ногоон бичил санхүүжилт яагаад чухал вэ?
 - ▶ Тогтвортой бичил санхүүгийн зарчмууд
 - ▶ Ногоон бичил санхүү нь Тогтвортой хөгжлийн зорилтуудтай хэрхэн уялдах вэ?

Тогтвортой хөгжил

”Ирээдүй хойч үеийнхний
хэрэгцээгээ хангах боломжийг алдагдуулахгүйгээр
өнөөдрийнхөө хэрэгцээг хангах”



(НҮБ-ын Хүрээлэн буй орчин ба Хөгжлийн даян дэлхийн комисс, 1987)

Тогтвортой хөгжлийн зорилтууд

Хүн төрөлхний байгаль орчин, нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөө улам бүр нэмэгдсэнтэй холбоотойгоор **“Тогтвортой хөгжил”** 1980-д оноос үүссэн.

Тогтвортой хөгжлийн зорилтууд нь **нийгэм, эдийн засаг, байгаль орчин** гэсэн гурван тулгуурт суурилсан, урт хугацааны хөгжлийн баримт бичиг болж батлагдсан бөгөөд дэлхий нийтээр хэрэгжүүлж байна.

MDGs

2000-2015



MDGs: 9 goals, 24 targets, 67 indicators



SDGs

2016-2030



SDGs: 17 goals, 169 targets, 244 indicators

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтууд

“МУ-н тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийг 2016 онд баталсан.

МУ-н тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үндсэн чиглэл:

- Эдийн засгийн тогтвортой хөгжил
- Нийгмийн тогтвортой хөгжил
- Байгаль орчны тогтвортой хөгжил
- Тогтвортой хөгжлийн засаглал

“Алсын хараа 2050”-д тогтвортой хөгжлийн үзэл баримтлал агуулгаараа багтсан байна. (2020.5.25-нд УИХ-с баталсан)



Тогтвортой хөгжлийн зорилтууд

“Алсын хараа 2050”

Зорилго 6.

Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна.



Тогтвортой хөгжил



Тогтвортой санхүү


Эх сурвалж: Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл, 2017

Тогтвортой санхүү

Байгаль орчин, нийгмийн болон засаглалын шалгуур үзүүлэлтүүдийг аливаа санхүүгийн шийдвэр гаргалтад ашиглах нь тогтвортой санхүүгийн суурь зарчим юм.



Тогтвортой санхүү



Карбон бага

Уур амьсгал

Ногоон

Тогтвортой

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН АСУУДАЛ

- Уур амьсгалын өөрчлөлт
- Экосистемийн доройтол
- Биологийн олон янзын байдлын хомсдол
- Байгаль орчны бохирдол
- Цөлжилт
- Ядуурал
- Хүний эрх
- Орлогын ялгаатай байдал
- Хүйсийн эрх тэгш байдал
- Байгалийн нөөцийн хомсдол
- Эрчим хүчний хэрэглээний өсөлт
- Хүнсний аюулгүй байдал
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа

Монгол Улс Йэлийн их сургуулиас 2016 онд хийсэн Байгаль орчны гүйцэтгэл индексээр 178 орноос 114-д эрэмбэлэгдсэн байна. *(Эх сурвалж: АХБ, Хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтийн үнэлгээ, 2017-2020)*

Хур тунадасны хэмжээ нэмэгдэх

Ган, зуд болох

Далайн түвшин нэмэгдэх

Гол, мөрөн ширгэх


Цөлжилт

Мөнх цэвдэг гэсэх

Агаарын хэм халах гэх мэт...

1996 оноос хойшхи хугацаанд байгалийн онц үзэгдлийн давтамжийн үзүүлэлт нэг дахин нэмэгдсэн бөгөөд 2050 он гэхэд 23– 60 хувиар өсөх тооцоолол хийгдсэн байна. (Эх сурвалж: АХБ, Хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтийн үнэлгээ, 2017-2020)

Байгаль орчин, нийгмийн асуудлуудтай холбоотойгоор санхүүгийн байгууллагад учрах эрсдэл



Байгаль орчин, нийгмийн асуудлуудын санхүүгийн байгууллагад учруулах эрсдэл

ОУСК-ийн тодорхойлсоноор компаниуд БОН-ийн дараах 4 төрлийн эрсдэлтэй нийтлэг тулгардаг.

1. Хүрээлэн буй орчны
2. Ажлын байрны эрүүл, аюулгүй орчинтой холбоотой
3. Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой
4. Нийгмийн эрүүл мэнд аюулгүй байдалтай холбоотой

БОН-ийн эрсдэлийг тооцоогүй, удирдаж чадаагүйгээс санхүүгийн байгууллагад учрах эрсдэл нь:

Хариуцлагын эрсдэл:

- Хуулийн хариуцлага
- Иргэний нийгмийн дарамт
- Торгууль
- Шүүхийн маргаан
- Хориг арга хэмжээ /лицензээ алдах/

Зээл, Санхүүгийн эрсдэл:

- Хугацаа хэтэрсэн зээл нэмэгдэх
- Чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх
- Барьцаа хөрөнгийн үнэлгээ бууруулах
- Төсөл саатах

Нэр хүндийн эрсдэл:

- Нэр хүнд, брэндийн үнэ цэнэ буурах
- Харилцагчаа алдах
- Зах зээлийн байрь суурь алдагдах
- Өрсөлдөх чадвар бууруулах

Тогтвортой санхүүгийн олон улсын зарчим, санаачлагууд

Тогтвортой санхүүгийн зарчим, санаачлагуудыг “албан” болон “сайн дурын” гэж ангилдаг.

- ▶ **Албан:** Тухайн улсын төв банк, зохицуулагч байгууллага болон эрх бүхий байгууллагын гаргасан хууль эрхзүй, зохицуулалтын шаардлагын дагуу үйл ажиллагаандаа заавал нэгтгэсэн байх бодлого, арга хэмжээ
- ▶ **Сайн дурын:** Санхүүгийн байгууллага өөрийн бодлоготойгоо уялдуулан тогтвортой санхүүг сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд туслах олон улсын сайн туршлага, зарчмууд



ОУСК-ийн Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт – 8 стандарт




ЕСБХБ-ийн Гүйцэтгэлийн шаардлагууд – 10 шаардлага



НҮБ-ийн Байгаль орчны хөтөлбөрийн санаачлагаас Хариуцлагатай банкны зарчмуудыг 2019 онд гаргасан– 6 зарчим

Тогтвортой санхүүгийн ач холбогдол

- ▶ Санхүүгийн байгууллагууд олон улсаас хямд эх үүсвэр татах боломж
- ▶ Эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо сайжруулах боломж
- ▶ Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжүүлэх, зах зээлд нэвтрүүлэх боломж
- ▶ Шинэ харилцагч, зах зээлээ тэлэх боломж
- ▶ Нэр хүнд өсөх



Эх сурвалж: IFC survey_2005

Монгол Улсын СЗЗ-ийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр



Бичил санхүү

- ▶ Бичил зээлийн түүх 1600-аад оноос үүсэлтэй.
- ▶ Орчин үеийн бичил зээлийн түүхийг 1980 онд Форд сангаас Grameen банкинд батлан даалтын сан байгуулснаар эхэлсэн гэж үздэг. *(Бангладешийн эрдэмтэн Мухаммед Юнус үнэдслэсэн)*
- ▶ Бичил зээлийг ядуу буюу орлого багатай иргэдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, орон нутгийн байгууллагын тулхтай хөгжлийг хангах зорилгоор олгож эхэлсэн.
- ▶ Ядуу буюу орлого багатай иргэдэд бусдын адил хөрөнгөтэй болох, амьжиргааны тогтвортой эх үүсвэртэй байх, болзошгүй эрсдлээс орон гэрээ хамгаалах зэрэгт тулгуурлан санхүүгийн олон төрлийн үйлчилгээ шаардлагатай болсон.
- ▶ Бичил санхүүгийн олон төрөлт бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох өгөөжтэй ба найдвартай арга замыг олох нь БСБ-уудын гол зорилт байсан.



Бичил санхүү

- ▶ “Мэдлэгийн менежмент бол бичил санхүүгийн ирээдүй” Claudio Gonzalez Vega бичил санхүүгийн ирээдүй бүтээлдээ дурьджээ. (Эх сурвалж: *Ira W.Lieberman and others, The Future of Microfinance, 2020*)
- ▶ Эдийн засгийн шинжлэх ухааны 2015 оны нобелийн шагналт эрдэмтэн Angus Deaton “Агуу зугталт” номондоо сүүлийн гурван зууны туршид хүн төрөлхтний гайхалтай хөгжил дэвшил нь шинэ мэдлэгийг бий болгож, түгээн дэлгэрүүлсэнтэй холбоотой гэж үзжээ.
- ▶ Бичил санхүү нь тодорхой нөхцөл байдалд ядуурлыг бууруулах, хүн амын эмзэг байдлыг бууруулахад хувь нэмэр оруулах чадвартай мэдлэгийн төвлөрөл юм гэж үзсэн байна.

Бичил санхүү

- ▶ Бичил санхүү нь хадгаламж, зээл, мөнгөн гуйвуулга, төлбөр тооцоо, даатгал зэрэг уламжлалт санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг авч чаддаггүй иргэд болон бичил бизнес эрхлэгчдийн санхүүгийн амьдралыг удирдах хэрэгсэл юм.
- ▶ Санхүүгийн үйлчилгээ нь орлого багатай хүмүүст мөнгө шилжүүлэх, хүлээн авах, бүтээмжээ дээшлүүлэх, хэрэглээний жигд байдлыг хангах, гэнэтийн санхүүгийн хүндрэлд оруулахгүй байх зорилгоор бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдэд хөрөнгө оруулах боломжийг олгодог.
- ▶ Бичил санхүү нь ядуурлыг бууруулах, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг дэмжихэд санхүүгийн чухал хэрэгсэл болж байна.

Бичил санхүү

- ▶ Уламжлалт бичил санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ технологийн асар хурдтай өөрчлөлт, шинэчлэлийн нөлөөгөөр хувьсан өөрчлөгдөж байна.
 - ▶ Уламжлалт бизнес модел  Дижитал бизнес модел
 - ▶ Уламжлалт зээл  Цахим зээлийн бүтээгдэхүүн
- ▶ Хандлагын өөрчлөлтүүд
 - ▶ Өрсөлдөөн нэмэгдэх
 - ▶ Бүтээгдэхүүний төрөл
 - ▶ Ядуурлыг бууруулах гэхээсээ илүү тогтвортой байдлыг хангах
 - ▶ Санхүүгийн байгууллагууд өөрт учрах эрсдэл, зардлаа бага байлгах гэхээсээ илүү төвлөрсөн байдлаар илүү хүртээмжтэй байлгах

Санхүүгийн хүртээмж нь тогтвортой хөгжлийн зорилгод хүрэх хэрэгсэл

- ▶ Энэтхэг
- ▶ БНХАУ
- ▶ Латин Америк
- ▶ Өмнөд Азийн улсууд

Тогтвортой бичил санхүү

Тогтвортой бичил санхүү гэдэг нь ердийн санхүүгийн үйлчилгээ авч чадахгүй байгаа хувиараа бизнес эрхлэгч, бичил болон ЖДААН-д **эдийн засгийн боломж** олгох цэвэр, уян хатан, тогтвортой байдлаар **санхүүгийн үйлчилгээ** (санхүүгийн үйлчилгээний нэг хэсэг болох санхүүгийн бус үйлчилгээ) **ҮЗҮҮЛЭХ** үйл ажиллагаа.

Тогтвортой бичил санхүүгийн гурван тулгуурт зорилго



Тогтвортой санхүүгийн зарчмаар санхүүжүүлэх төсөл нь хөрөнгө оруулагчдаа ашигтай байхаас гадна байгаль орчин, нийгэмдээ хор хохирол учруулахгүй байх ёстой.

Тогтвортой ба ногоон бичил санхүү

- “**Ногоон бичил санхүү**” нь эдийн засаг, нийгэм, байгаль орчны зорилтуудыг хангахын тулд бага орлоготой хүмүүст зээл олгох болон техникийн тусламж, дэмжлэг үзүүлэх зэргээр тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах хамгийн үр нөлөөтэй хэрэгсэл юм.
- Байгаль орчны өөрчлөлт, доройтолд нийгмийн хамгийн эмзэг бүлэг ихээр өртөх магадлалтай байдаг тул тэднийг хамгаалахад бичил санхүүгийн байгууллагын үүрэг роль чухал байна.
- Ногоон бичил санхүүг хөгжүүлэх, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэхэд санхүүгийн байгууллагын удирдлагын ойлголт, дэмжлэг маш чухал байна.

Тогтвортой бичил санхүүгийн зарчмууд

- ▶ Зарчим 1 – Бичил санхүүгийн үйлчилгээ нь үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцсэн байх ёстой.
- ▶ Зарчим 2 – Ядуу өрх болон нийгмийн бүлэг нь зээлээс гадна бусад олон төрлийн санхүүгийн үйлчилгээ ашиглах хэрэгцээтэй байдаг.
- ▶ Зарчим 3 – Бичил санхүү нь ядуурлыг бууруулах хүчирхэг хэрэгсэл байх.
- ▶ Зарчим 4 – Бичил санхүү нь нийгмийн доод бүлэгт үйлчлэх санхүүгийн системийг бүрдүүлэхэд чиглэх ёстой.
- ▶ Зарчим 5 – Санхүүгийн тогтвортой байдал нь тодорхой тооны ядуу буурай иргэдэд хүрч үйлчлэх, хүртээмжтэй байдлыг хангах ёстой.

Тогтвортой бичил санхүүгийн зарчмууд

- ▶ Зарчим 6 – Хүүний түвшний дээд хязгаар нь ядуу буурай иргэдийн санхүүгийн үйлчилгээ авахад таагүй байдлыг үүсгэдэггүй байх.
- ▶ Зарчим 7 – Хүн бүрт тохиромжтой зээлийн үйлчилгээ гэж байдаггүй.
- ▶ Зарчим 8 – Засгийн газрын үүрэг нь аливаа зүйлийг боломжтой байлгах явдал бөгөөд, харин санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч биш юм.
- ▶ Зарчим 9 – Хандивлагчдаас өгсөн мөнгөн тусламж нь нэмэгдэл юм.
- ▶ Зарчим 10 – Байгууллагын болон хүний нөөц бололцоо дутуу байгаа нь бичил санхүүгийн тэлэлтийг хязгаарлах гол хүчин зүйл юм.
- ▶ Зарчим 11 - Санхүүгийн болон мэдээллийн ил тод байдал чухал ач холбогдолтой.

Бичил ногоон санхүүжилт

“Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр”

(МБ-ны ерөнхийлөгч, СЗХ-ны дарга, Сангийн сайд, ХДК-ийн гүйцэтгэх захирлын хамтарсан тушаал 2021.03.01)

Зорилго 3.

Бичил санхүүжилт, жижиг дунд үйлдвэрлэл, ногоон санхүүжилтээр дамжуулан банкнаас бусад санхүүгийн зах зээлийн санхүүжилтийн орчныг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Ногоон бичил санхүүжилт яагаад чухал вэ?

- ▶ Бичил санхүүгийн хамгийн том давуу тал нь санхүүгийн үйлчилгээний хүртээмжтэй байдлыг нийгмийн бүхий л давхаргынханд хүргэх байдаг учраас бичил санхүүгийн салбарт байгаль орчинд ээлтэй байх шаардлагыг тавьснаар тогтвортой хөгжлийн зорилтод хүрэхэд чухал нөлөө үзүүлнэ.

Санхүүгийн хүртээмж


Санхүүгийн хүртээмж нь боломжит зардлын түвшинд санхүүгийн үйлчилгээг хүргэх байдлыг хэлнэ. Боломжит зардал болон чанар нь мөнгөн, мөнгөн бус зардлууд болон стандарттай хамааралтай байна. *(RashmiUmeshArora, 2010)*

Санхүүгийн үйлчилгээний хүртээмж гэдэг нь нийлүүлэлт тал, эрэлт тал болон бодлогын тал болгон ач холбогдлоор нь бүлэглэн авч үзэж буй санхүүгийн үйлчилгээний нөхцөл байдлыг хэлнэ. *(Microfinance Centre, 2009)*

Санхүүгийн хүртээмж нь санхүүгийн хөгжлийн бүрэлдэхүүн хэсэг юм. Санхүүгийн хөгжил нь олон хүчин зүйлээс шалтгаалах боловч газарзүйн хувьд эсвэл орлогын хувьд бүлэг болгон санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг тооцох нь чухал юм. *(FinMark Trust , 2009)*


Санхүүгийн хүртээмж нь ядуу болон бага орлоготой зэрэг ангилан авч үзэж буй бүлгүүдэд санхүүгийн үйлчилгээг авах боломж хэр байгаа болохыг харуулдаг. *(Vijay Mahajan, Suman Laskar, 2009)*

Санхүүгийн үйлчилгээний хүртээмж, ашиглалтын байдал



Монгол улсын санхүүгийн үйлчилгээний хүртээмж

100.000 ХҮНД НОГДОХ БАНКНЫ САЛБАРЫН ТОО



Эх сурвалж: (Монгол улсын санхүүгийн хүртээмж, 2015)

Хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлт

Санхүүгийн эх үүсвэр хангалттай нээлттэй бус

(Эх сурвалж: АХБ, Хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтийн үнэлгээ, 2017-2020)

- ▶ Арилжааны банкууд санхүүгийн секторт голлох үүрэгтэй
- ▶ Санхүүгийн зах зээлийн өрсөлдөөн сул
- ▶ Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын 90 хувь нь, нийт ажлын байрны 50 хувийг ЖДҮ-үүд бүрдүүлдэг
- ▶ ЖДҮ-ийн 90 гаруй хувь нь банк санхүүгийн байгууллагаас тогтмол санхүүжилт авах боломжгүй
- ▶ Санхүүгийн боловсрол сул
- ▶ Санхүүгийн салбарын хэрэглэгч болон хөрөнгө оруулагчийг хамгаалах эрх зүйн зохистой орчин хараахан бүрдээгүй байна.

Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ядуу иргэдэд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртээмжтэй болгох талаар авч хэрэгжүүлсэн олон улсын кейс туршлага

Улс орон	Хэрэгжүүлсэн хугацаа, байгууллага	Авсан арга хэмжээ	Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр	Үр дүн
Шри Ланк	Үндэсний хөгжлийн итгэлийн сан /ҮХИС/, 1991 он	ТББ, банкуудыг дамжин зээлдүүлэгч болгон ядууст барьцаа хөрөнгөгүй зээл авах боломж олгодог.	Энэ байгууллагын гол үйл ажиллагаа нь ядуурлыг бууруулах зорилгоор нийгмийн ядуу хэсгийнхэнд бичил зээлийг хүргэх хөтөлбөр хэрэгжүүлэх явдал юм	1990 онд хадгаламж болон зээлийн хэмжээ тус тус 491, 448 сая байсан бол 2003 онд буюу 13 жилийн дотор маш хурдацтай өсөж хадгаламжийн хэмжээ 4205 сая болон зээлийн хэмжээ 2844 сая болсон байна.
Япон	Японы санхүүгийн корпораци (JFC), 2003 он	Батлан даагчгүй эсвэл барьцаагүй зээл авахыг хүсдэг бичил болон жижиг байгууллагуудын хэрэгцээнд нийцсэн зээл олгож эхэлсэн.	JFC-Micro зээлийн хөтөлбөр, Банк болон бусад санхүүгийн байгууллагууд өгдөггүй бичил зээлийг JFC микро санхүүгийн байгууллага нь олгодог.	Барьцаа хөрөнгөгүй зээлдэгчид 80% буюу хамгийн их хувийг эзлэхээс гадна 3-5 жилийн буюу дунд хугацааны зээлүүд 72%-ийг эзэлж байна. Нийтэд нь дүгнэхэд бичил хэмжээний бага хугацаатай барьцаа хөрөнгө болон бага хөрөнгө оруулалттай зээлдэгчид ихэнх хувийг эзлэх болсон.
Энэтхэг		Ядуу иргэдийг зохион байгуулж, ихэвчлэн 15-20 эмэгтэйг нэг бүлгэм болгон тэднийг хуримтлалтай болох байнгын зуршлыг бий болгоход нь тусалдаг.	Өөртөө туслах бүлгэм – Банкуудыг жирийн иргэдтэй холбох хөтөлбөр	Хөрөнгийн хэмжээ дундажаар 72% өссөн ба 1 гишүүнд ногдох дундаж хадгаламж гурав дахин нэмэгдсэн. Өрх гэр тус бүрт ногдох дундаж зээл Rs4,282-оос Rs8,341 болон өссөн, ажил эрхлэлт дундажаар жилийн 318 өдрөөс 375 өдөр болж, тариалангийн бус үйл ажиллагаанаас үүссэн ажил эрхлэлтийн хэмжээ өссөн,

Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ядуу иргэдэд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртээмжтэй болгох талаар авч хэрэгжүүлсэн олон улсын кейс туршлага

Улс орон	Хэрэгжүүлсэн хугацаа, байгууллага	Авсан арга хэмжээ	Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр	Үр дүн
Лаос	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн (GIZ) захиалгаар Австралийн тусламжийн байгууллага (Australia Aid), MMG уул уурхайн компани хамтран санхүүжүүлснээр төсөл, 2009 он	Төслийн хүрээнд санхүүгийн хүртээмж ба эмэгтэйчүүдийн санхүүгийн оролцоо, хөдөө орон нутгийн иргэдийн санхүүгийн боловсрол, хөдөө орон нутгийн санхүүгийн эрэлт, эмэгтэйчүүдийн санхүүгийн хүртээмж гэх санал асуулгыг иргэдээс авчээ.	Лаос улсад хэрэгжиж буй “Хөдөө орон нутаг дах бичил санхүү – Ядуу иргэдийн санхүүгийн хүртээмж” төсөл	2014 оны 11 сар гэхэд 37,000 данс бүхий 430 тосгоны банкны суурийг тавьсан. Эдгээр дансуудын дийлэнх нь өрх гэрийн данс байх ба хувийн данс эзэмшигчдийн 55%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Төслийн үр дүнд шийдвэр гаргах байр сууринд байх эмэгтэйчүүдийн тоо 28%-аар нэмэгджээ. Нийт хуримтлуулсан хадгаламжийн хэмжээ одоогын байдлаар 31 тэр бум кип (3.1 сая евро) даваад байгаа бөгөөд хуримтлуулсан хадгаламжийн өсөлт 73.6 хувьтай байна.

Эх сурвалж: Санхүүгийн үйлчилгээний хүртээмж, 2015

Ногоон зээл, санхүүжилтийн талаар авч хэрэгжүүлсэн олон улсын кейс туршлага

Улс орон	Хэрэгжүүлсэн хугацаа, байгууллага	Авсан арга хэмжээ	Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр	Үр дүн
Бангладеш	-Бангладешийн төв банк, Дотоодын банк, санхүүгийн байгууллагууд, 2009 он	Ногоон бүтээгдэхүүний дахин санхүүжилтийн схемийг бүрдүүлсэн.	<ul style="list-style-type: none"> Нарны эрчим хүч Био хийн төхөөрөмж Бохир ус цэвэрлэх байгууламж 	СБ-уудад ногоон технологийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлж, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн бий болгож, илүү тогтвортой болгоход дэмжлэг болсон.
БНХАУ	IFC, Хятадын ЗГ, Даян дэлхийн байгаль орчны тусламжийн хөтөлбөр, 2006	Хэрэглээнд суурилсан эрчим хүчний үр ашгийн санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжүүлсэн.	<ul style="list-style-type: none"> Уур амьсгалын өөрчлөлтөд ээлтэй эрчим хүчний үр ашгийн сайжруулалт Сэргээгдэх эрчим хүчний төсөл 	Хятадын эрчим хүчний салбарын нийлүүлэлт дэх хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулж, ЖДҮ-дэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.
Вьетнам	Швейцарын ЭЗХГ, Канадын Роял Банк, Дотоодын санхүүгийн байгууллагууд, 2007	Ногоон зээлийн сан байгуулсан.	<ul style="list-style-type: none"> Тэтгэлэг Зээлийн баталгаа 	Вьетнамын ЖДҮ-үүдэд үйлдвэрлэлийн технологид хийх хөрөнгө оруулалтыг дэмжсэн.
Малайз	Негара Малайзын банк, Сангийн яам, Эрчим хүч, ногоон технологи усны яам, 2009	Ногоон технологийн санхүүжилтийн схемийг бүрдүүлсэн.	<ul style="list-style-type: none"> Байгаль орчны доройтол, Хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах, Эрчим хүч, байгалийн нөөцийн хэрэглээг бууруулах, Сэргээгдэх эрчим хүчний төслүүд 	Шинэлэг ногоон технологийн компаниудад санхүүгийн дэмжлэг, ногоон технологийн хөгжилд дэмжлэг болсон.
Энэтхэг	Энэтхэгийн үндэсний нөөцийн сан, KfW Банк, Дотоодын СБ-ууд, 2010	Эрчим хүчний хэмнэлтийн шошгожуулалт, гэрчилгээжүүлэлтийн механизмыг бүрдүүлсэн.	Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны хөтөлбөр	Шинэ орон сууцны барилгад эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлсэн.

Санхүүгийн хүртээмж-Бичил санхүү-Тогтвортой санхүү

- ▶ Бичил бизнес эрхлэгчдэд хүрэх санхүүгийн хүртээмж үйлчилгээг сайжруулснаар зөвхөн улсын эдийн засагт төдийгүй санхүүгийн байгууллагуудад /зээлдүүлэгчдэд/ ч ашигтай.
- ▶ Санхүүгийн салбар сайжирснаар дараах үр дүнд хүрнэ.
 - ▶ Эдийн засгийн өсөлтөд дэмжлэг болно,
 - ▶ Ажилгүйдэл буурна,
 - ▶ Орлогын үр ашигт хуваарилалт нэмэгдэнэ,
 - ▶ Ядуурлын түвшин багасна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.